



**ОРХОН АЙМГИЙН
НИЙГМИЙН ДААТГАЛЫН ГАЗАР
ХЯНАЛТ ШАЛГАЛТЫН
ТАНИЛЦУУЛГА**

2025 оны 05 сарын 14 өдөр

Дугаар 08-07/06

Баян-Өндөр сум

**АЖИЛГҮЙДЛИЙН ДААТГАЛЫН САНД
УРЬДЧИЛАН СЭРГИЙЛЭХ ХЯНАЛТ
ШАЛГАЛТ ХИЙСЭН ТУХАЙ**

Нэг. Шалгалтын зорилго, үндэслэл

Төрийн хяналт шалгалтын тухай хуулийн 5³ дугаар зүйлийн 5^{3.1} дэх хэсэг, Монгол улсын Хяналт, үнэлгээний Үндэсний хорооны “Хяналт шалгалтын төлөвлөгөө батлах тухай” 2024 оны 02 дугаар тогтоолыг тус тус үндэслэн Гэр бүл, хөдөлмөр, нийгмийн хамгааллын яамны Салбарын улсын ерөнхий байцаагчийн 2025 оны 01 дүгээр сарын 07-ны өдөр баталсан 08-07/06 дугаар “Ажилгүйдлийн даатгалын санд урьдчилан сэргийлэх хяналт шалгалт хийх тухай” удирдамжийн дагуу Ажилгүйдлийн даатгалын сангийн 2022-2024 оны орлогын бүрдүүлэлт, зарцуулалтад Төрийн хяналт шалгалтын тухай хуулийн хүрээнд Нийгмийн даатгалын ерөнхий хууль, Нийгмийн даатгалын сангаас олгох ажилгүйдлийн тэтгэмжийн тухай хууль болон тэдгээрт нийцүүлэн гаргасан дүрэм, журмын хэрэгжилтэд шалгалт хийж, илэрсэн зөрчил дутагдлыг арилгуулж, мэргэжил арга зүйн зөвлөгөө өгч, цаашид авах арга хэмжээний санал боловсруулж, дүгнэлт өгөх, эрсдлээс урьдчилан сэргийлэхэд оршино.

Хоёр. Хяналт шалгалт хийсэн бүрэлдэхүүн, хугацаа

Ажилгүйдлийн даатгалын сангаас ажилгүйдлийн тэтгэмж олгохдоо Нийгмийн даатгалын ерөнхий хууль, Нийгмийн даатгалын сангаас олгох ажилгүйдлийн тэтгэмжийн тухай хууль, тэдгээрт нийцүүлэн гаргасан дүрэм, журмын хэрэгжилтийг хэрхэн хангасан байдалд урьдчилан сэргийлэх шалгалтыг 2025 оны 03 дугаар сарын 10-ны өдрөөс 2025 оны 05 дугаар сарын 10-ны өдрийг хүртэлх хугацаанд Орхон аймгийн Нийгмийн даатгалын газрын Нийгмийн хамгааллын хяналтын улсын байцаагч А.Уранчимэг хийж гүйцэтгэлээ.

Гурав. Хяналт шалгалтад хамрагдсан асуудал

Шалгалтаар Ажилгүйдлийн даатгалын сангийн тэтгэмжийн баримт болох

- 2022 оны 970 даатгуулагчийн хувийн хэрэг, 46 боть архивын хадгаламжийн нэгж,
- 2023 оны 877 даатгуулагчийн хувийн хэрэг, 44 боть архивын хадгаламжийн нэгж,
- 2024 оны 915 даатгуулагчийн хувийн хэрэг, 35 боть архивын хадгаламжийн нэгж,

нийт 2762 хувийн хэрэг бүхий 125 боть баримт, банкны баримт 2022 он 2 баримт, 2023 он 3 баримт, 2024 он 3 баримт материалууд шалгалтад хамрагдсан.

Ажилгүйдлийн даатгалын сангийн 2022-2024 оны орлого, зарлагын нэгдсэн товчоо хүснэгт №-01, орлогын бүрдүүлэлт хүснэгт №-02, зарцуулалт хүснэгт №-03, ажилгүйдлийн тэтгэмж авч байгаа даатгуулагдын ажлаас чөлөөлөгдсөн шалтгаан хүснэгт №-04,

шалгалтаар илэрсэн төлбөр зөрчлийн дүн хүснэгт №-05, зөрчлийн дүнгийн нэгтгэл хүснэгт №-06-аар нэгтгэн гаргалаа.

Дөрөв. Шалгуулагч этгээд, хяналт шалгалтын объектын талаарх мэдээлэл

Орхон аймгийн Нийгмийн даатгалын газар нь Удирдах албан тушаалтан 1, гүйцэтгэх төрийн захиргааны ажилтан 31, төрийн үйлчилгээний ажилтан 8, нийт батлагдсан 40 орон тоотойгоор ажиллаж байна. Нийт 4 хэлтэстэйгээс Захиргаа, хяналтын хэлтэс 12, Санхүү бүртгэл хөрөнгө оруулалтын хэлтэс 4, Хамралт орлогын хэлтэс 5, Тэтгэвэр тэтгэмжийн хэлтэс 10, Нэг цэгийн үйлчилгээ, цахим мэдээллийн тасаг 8, Жаргалант сумын байцаагч 1 орон тоотой.

Сангийн хөрөнгийн зарцуулалтад нэгдүгээр гарын үсэг НДЕГ-ын даргын 2023.01.23-ны өдрийн Б/14 тоот тушаалаар Газрын даргын албан үүргийг түр орлон гүйцэтгэгч Д.Нармандах, хоёрдугаар гарын үсэг НДХ-ийн даргын 2023.01.25-ны өдрийн Б/12 тоот тушаалаар Санхүү бүртгэлийн тасгийн дарга, ахлах нягтлан бодогч Ү.Мягмарсүрэн нар гарын үсэг зурж байна.

Тав. Өмнөх хийсэн хяналт шалгалтын түүх

Нийгмийн даатгалын ерөнхий газрын Хяналт шалгалтын газраас 2019 онд нийгмийн даатгалын хуулийн хэрэгжилтийг шалгах шалгалтын нэгдсэн удирдамжаар тус газрын 2016, 2017, 2018 онуудын санхүүгийн баримтуудад шалгалт орж, ажилгүйдлийн даатгалын санд шүүхийн шийдвэрээр эргүүлэн ажилдаа орсон 2 даатгуулагчдад олгосон 7.1 сая төгрөгийн тэтгэмжийг нөхөн төлүүлэх тухай Улсын байцаагчийн 32/85 тоот акт тавигдаж, 100% барагдуулсан байна.

Зургаа. Хяналт шалгалтаар тогтоогдсон бодит нөхцөл байдал

6.1 Орхон аймгийн Нийгмийн даатгалын газрын Ажилгүйдлийн даатгалын сангийн 2022-2024 оны орлого, зарлагын нэгдсэн товчоо хүснэгт №-01, орлогын бүрдүүлэлт хүснэгт №-02, зарцуулалт хүснэгт №-03-аар тус тус гаргаж, сангийн орлого, зарлагад дүн шинжилгээ хийж, дүгнэлт өгөхөд орлогын төлөвлөгөө 2022 онд 95.1%, 2023 онд 91.9%, 2024 онд 93.8%-тай төлөвлөсөн байна.

Хүснэгт 1 (2022-2024 оны Ажилгүйдлийн даатгалын сангийн орлого, зарлагын нэгтгэл. Сая төгрөгөөр)

Орхон аймгийн Нийгмийн даатгалын газар			2022 он	2023 он	2024 он	Нийт
Эхний үлдэгдэл			139.1	110.9	138.5	388.5
Орлого	Шимтгэлийн орлого	Төлөвлөгөө	2067.4	2692,8	5865.7	10625.9
		Гүйцэтгэл	1966.8	2474.2	5505.4	9946.4
		Хувь	95.1	91.9	93.8	93.6
	Бусад орлого		147.3	433.4	3193.4	3774.1
	Орлогын нийт дүн		2114.1	2907.6	3193.4	8215.2
Зарлага	Ажилгүйдлийн тэтгэмж олгосон		2142.3	2880.1	3326.2	8348.6
	Төвлөрүүлсэн		0	0	0	0
	Бусад зардал		0	0	4.2	4.2
	Зарлагын нийт дүн		2142.3	2880.1	3330.4	8352.8
Эцсийн үлдэгдэл			110.9	138.5	1.5	205.9

Шалгалтад хамрагдсан 2762 ажилгүйдлийн хувийн хэргээс ажилгүйдлийн тэтгэмж авсан даатгуулагчийн тоо болон тэтгэмж олгоогүй шалтгааныг ангилж харуулвал:

Хүснэгт 2

д/д	Тоо бүртгэл	2022 он	2023 он	2024 он	Нийт
1	Ажилгүйдлийн хувийн хэргийн тоо	970	877	915	2762
2	Тэтгэмж авсан даатгуулагчийн тоо	940	854	902	2696
3	Тэтгэмж олгоогүй даатгуулагчийн тоо	30	23	13	66
Олгоогүй шалтгаан	Үүнээс: ажилд орсон	19	18	4	41
	эрх үүсээгүй	1	2	-	3
	ажил олгогч өртэй	3	2	8	13
	суралцах тушаалтай	2	-	-	2
	хугацаа хэтэрсэн	1	1	-	2
	харьяаллын бус	2	-	-	2
	ажлаасаа гараагүй	1	-	1	2
	програмд давхар оруулсан	1	-	-	1

Ажилгүйдлийн тэтгэмж авсан нийт 2696 даатгуулагчдын тэтгэмжийн хувийн хэргийг санхүүгийн баримтад тулган шалгаж, ажлаас чөлөөлөгдсөн шалтгаан, үндэслэлээр ангилж үзвэл:

Хүснэгт 3

д/д	Ажлаас чөлөөлөгдсөн шалтгаан	2022 он	2023 он	2024 он	Нийт
1	Өөрийн хүсэлтээр	718	682	614	2014
2	Бүтэц, орон тооны цомхотголоор	27	33	66	126
3	Эрүүл мэндийн шалтгааны улмаас	6	6	2	14
4	Хууль бусаар халагдсан	1	1	-	2
5	Захиргааны санаачилгаар	71	68	89	228
6	Хөдөлмөрийн гэрээ дууссан	71	29	69	169
7	Бусад	46	35	62	143
	Нийт дүн	940	854	902	2696

Ажилгүйдлийн даатгалын сангаас 2022 онд 940 даатгуулагчдад 2,1 тэмбум, 2023 онд 854 даатгуулагчдад 2,9 тэрбум, 2024 онд 902 даатгуулагчдад 3,3 тэрбум төгрөгийн, нийт 8,3 тэрбум төгрөгийн ажилгүйдэл олгосон. Үүнээс тэтгэмжийн илүү олголт 2022 онд 2 даатгуулагчдад 836,8 мянга, 2023 онд 8 даатгуулагчдад 4.7 сая төгрөгийн улсын байцаагчийн акт үйлдсэн байна. Энэ нь илүү олгосон ажилгүйдлийн тэтгэмж ажилгүйдлийн даатгалын санд орж ирсэн үед тухайн өдрөөр нь улсын байцаагчийн акт үйлддэг байсан зөрчил илэрч байна.

Харин 2024 онд Sicos програм нэвтэрч, програмын хөгжүүлэлт гүйцэт хийгдээгүйгээс ажилгүйдлийн олголт дээр улсын байцаагчийн акт тавигдаагүй, 2025 оны эхний улиралд 2024 оны ажилгүйдлийн олголт дээр 8 даатгуулагчидтай холбоотой 11,2 сая төгрөгийн улсын байцаагчийн акт тавигдсан байна. (Хүснэгт 4)

Sicos програм нь ажилгүйдлийн тэтгэмж олгох хуваарийг сар дамнуулж тооцдог нь тэтгэмжийн байцаагчийн тооцоололтой зөрснөөс болж байцаагчид өөрсдөө эксел програм дээр олгох хуваарь гаргасан. Энэ нь гар ажиллагаагаар хийгдсэнээс олгох мөнгөн дүнтэй зөрөх тохиолдол цөөнгүй гарлаа. Үүний 4 даатгуулагчид илүү олгосон 8.4 сая төгрөгийн зөрчил болон 2 даатгуулагчид 949.3 мянган төгрөг илүү олгосон, 2 даатгуулагч ажилд

орсоноор тушаалаа өгч, тооцоо нийлэн 1.8 сая төгрөгийн зөрчил дээр тэтгэмжийн олголтын байцаагч, тэтгэмжийн хяналтын байцаагч нар улсын байцаагчийн акт үйлдэж шийдвэрлэсэн байна.

Хүснэгт 4

д/д	Даатгуулагчийн овог нэр	Регистр	Тэтгэмж тогтоолгосон огноо	Илүү олгосон мөнгөн дүн	Зөрчлийн шалтгаан
1	Ж.ГАНЦЭЦЭГ		2024.03.31	412,985	олгох хуваарь буруу гаргасан
2	Э.БИЛГҮҮН		2024.06.28	449,758	олгох хуваарь буруу гаргасан
3	Г.ЭРДЭНЭСУВД		2024.07.16	286,249	олгох хуваарь буруу гаргасан
4	Х.СЭРГЭЛЭНТӨГС		2024.09.05	7,284,541	олгох хуваарь буруу гаргасан
5	Ч.УЛАМБАЯР		2024.01.01	19,243	илүү олгосон
6	Б.БУМБАЯР		2024.05.08	930,038	илүү олгосон
7	Б.АЛТАНШАГАЙ		2023.06.07	1,463,487	ажилд орсон
8	Д.ЛУВСАНБАЛДАН		2024.01.31	352,035	ажилд орсон
Нийт				11,198,336	

Мөн тэтгэмж олголтын байцаагч ажилгүйдлийн тэтгэмж авч байгаа даатгуулагчийн регистр дээр цалин гарахад ажилгүйдлийн тэтгэмжийг зогсоож, даатгуулагчид мэдэгдэн ажилд орсон тушаалын хуулбарыг авчирч, тооцоо нийлэхийг сануулдаг хэдий ч дахин эргэж холбогддоггүй, иргэн даатгуулагч ч тушаалын хуулбараа авчирч өгдөггүй нийтлэг зөрчил дутагдал гарч байна.

Sicos програмтай холбоотойгоор 2024 оны 1 дүгээр улирлын нийгмийн даатгалын шимтгэлийн тайлан авалт удаашралттай байсан нь ажилгүйдлийн тэтгэмж авч байгаа даатгуулагчийг дахин ажилд орсонг нягтлан шалгах боломжгүй байсан. Үүнээс үүдэн 2023 оны сүүлээрх тэтгэмж тогтоолтууд дээр илүү олголт нилээдгүй гарчээ.

Долоо. Хяналт шалгалтын явцад авсан арга хэмжээ, өгсөн зөвлөгөө:

Нийт 46 даатгуулагчидтай холбоотой 52,0 сая төгрөгийн улсын байцаагчийн акт тогтоосон. Үүний 28 даатгуулагчийн 30,4 сая төгрөгийн ажилгүйдлийн тэтгэмжийг санд буцаан төвлөрүүлэхээр, 18 даатгуулагчдад 21.6 сая төгрөгийг ажилгүйдлийн даатгалын сангаас нэг удаа нөхөн олгохоор байна. Үүнийг 2022, 2023, 2024 оны ажилгүйдлийн тэтгэмж тогтоолтоор ангилж харуулбал:

Хүснэгт 5

д/д	Он	Илүү олгосон		Дутуу олгосон		Нийт дүн	
		Даат гуулаг чийн тоо	мөнгөн дүн (сая.төг)	Даат гуулаг чийн тоо	мөнгөн дүн (сая.төг)	Даат гуулаг чийн тоо	мөнгөн дүн (сая.төг)
1	2022	10	9.9	8	4.4	18	14.3
2	2023	14	15.8	3	0.3	17	16.1

3	2024	4	4.7	7	16.9	11	21.6
нийт		28	30.4	18	21.6	46	52.0

Шалгалтын явцад 5 даатгуулагчтай холбоотой 5,3 сая төгрөгийг барагдуулж, үлдсэн илүү олголттой тэтгэмжийг тэтгэмжийн тогтоолт, олголт хариуцсан байцаагчдад хугацаатай үүрэг даалгавар өгч, барагдуулахыг анхааруулж ажиллалаа.

Мөн тэтгэмжийн баримт, материал хүлээн авдаг нэг цэгийн үйлчилгээ, цахим мэдээллийн тасгийн дарга, байцаагч нарт ажилгүйдлийн тэтгэмж авч байх хугацаандаа сайн дурын даатгалд хамрагдвал ирээдүйн нийгмийн баталгаа хангагдах, ажилд орвол нийгмийн даатгалын байгууллагад мэдэгдэж, тушаалаа цахимаар болон цаасаар авчирч тооцоо нийлж байхыг үйлчилгээ авсан даатгуулагчдад сайн ойлгуулан тайлбарлаж, өргөдөл дээр бичүүлж авч хэвшихийг зөвлөлөө.

Найм. Цаашид авах арга хэмжээний санал

- 8.1 Ажилгүйдэл авч байх хугацаандаа ажилд орсон, цалин гарсан үед ажилгүйдлийг зогсоож, даатгуулагчид мэдэгдэж тушаалын хуулбараа авчиргахыг сануулдаг. Удаа дараа залгаж хэлсэн ч ирдэггүй, хэзээ хойно нь, тушаалаа барьж ирж зөрүү мөнгөө авна гэдэг, иргэн даатгуулагч хүний хариуцлагыг чангатгамаар байна. Хугацаа зааж өгөх, түүнээс хойш тушаалаа авчирч өгсөн ч хоногийн тооцоог олгохгүй байх,
- 8.2 Sicos програмаас ажилгүйдлийн тэтгэмжийн тогтоолтын хуудас дээр даатгуулагчийн регистрийн дугаар, бүртгэлийн дугаар хэвлэгддэг болгох,
- 8.3 SICOS программ дээрх Олголт үүсгэх-Тэтгэмж-Ажилгүйдэл цэсэд олголт үүсгэх үед цалинтай болон тэтгэвэр авагчийн тухай мэдээллийг цахимаас татаж мэдэгдэл өгдөг байх,
- 8.4 Нийгмийн даатгалын сангаас олгох тэтгэмжийн тухай хуулийн 12 дугаар зүйлийн 12.1-12.6 дахь заалтуудад дурдсан шалтгаануудаар ажилгүйдлийн олголт хийх үед зогсоох мэдэгдэл ирдэг байх,
- 8.5 Ажил олгогч, нягтлан бодогч нар ажилд шинээр орсон, ажлаас чөлөөлөгдсөн, ажлын байр өөрчлөгдсөн даатгуулагчдын тушаалуудыг нийгмийн даатгалын тайланд хавсаргаж илгээдэг ч хариуцсан орлогын байцаагчдад харагддаггүй, үүнийг хяналт, шалгалтын байцаагч нарт харах эрхтэйгээр оруулж, шаардлагатай тушаалын хуулбарыг хэвлэж авдаг болгох програмын санал байна.

ХЯНАСАН:

НИЙГМИЙН ДААТГАЛЫН ГАЗРЫН ДАРГЫН АЛБАН
ҮҮРГИЙГ ТҮР ОРЛОН ГҮЙЦЭТГЭГЧ УЛСЫН АХЛАХ
БАЙЦААГЧ Д.НАРМАНДАХ

ТАНИЛЦУУЛГА БИЧСЭН:

НИЙГМИЙН ХАМГААЛЛЫН ХЯНАЛТЫН УЛСЫН
БАЙЦААГЧ А.УРАНЧИМЭГ